



**УВС АЙМГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН
ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 224/ЗТ2025/00031

Улаангом сум

**Эрүү, иргэн, зөрчлийн хэрэг, гомдол, хүсэлт хүлээн авах,
хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх
шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох,
шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох
журмыг шинэчлэн батлах тухай**

Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн ээлжит бус зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч Л.Алтан даргалан, шүүгч Б.Мөнхзаяа нарын бүрэлдэхүүнтэй, шүүгчийн туслах Ш.Анхцэцэгийг байлцуулан хийж, тус шүүхийн эрүү, иргэн, зөрчлийн хэрэг, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох, шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох нарийвчилсан журмыг шинэчлэн батлах тухай /цаашид “Хэрэг хуваарилах журам” гэх/ асуудлыг хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 183 дугаар зарлигаар шүүгч Б.Мөнхзаяа томилогдож, тус шүүх 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй шүүн таслах ажиллагаа явуулах болсон буюу шинээр шүүгч нэмэгдэн ажиллах болсонтой холбоотойгоор тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан “Хэрэг хуваарилах журам”-ыг дараах байдлаар шинэчлэн батлахаар шийдвэрлэлээ.

1. Тус шүүхэд ирсэн эрүү, иргэн, зөрчлийн хэрэг, гомдол, хүсэлтийг нэгдсэн системээс урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилахдаа ердийн журмаар хэрэг хуваарилах аргыг хэрэглэнэ. Нэгдсэн системд шүүгчдийн нэрсийг байршуулахдаа сугалаа сугалж, тойрог үүсгэв. Үүнд:

1.1. Эрүүгийн болон зөрчлийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд:

1.1.1. Шүүгч Б.Мөнхзаяа

1.1.2. Ерөнхий шүүгч Л.Алтан

1.1.3. Шүүгч Н.Мөнхжаргал гэсэн дарааллаар,

1.2. Иргэн-2014 нэгдсэн системд:

1.2.1. Ерөнхий шүүгч Л.Алтан

1.2.2. Шүүгч Б.Мөнхзаяа

1.2.3. Шүүгч Н.Мөнхжаргал гэсэн дарааллаар тус тус байршуулахаар тогтоов.

2. Шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг сугалаагаар тогтоосон дараах журмыг баримтална.

2.1. Ерөнхий шүүгч Л.Алтангийн илтгэх эрүү, иргэн зөрчлийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаан даргалагчаар: 1.шүүгч Б.Мөнхзаяа, 2.шүүгч Н.Мөнхжаргал гэсэн дарааллаар тойргийн журмаар,

2.2. Шүүгч Н.Мөнхжаргалын илтгэх эрүү, иргэн, зөрчлийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаан даргалагчаар: 1. шүүгч Б.Мөнхзаяа, 2. Ерөнхий шүүгч Л.Алтан гэсэн дарааллаар тойргийн журмаар,

2.3. Шүүгч Н.Мөнхзаяагийн илтгэх эрүү, иргэн, зөрчлийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаан даргалагчаар: 1. Ерөнхий шүүгч Л.Алтан, 2. шүүгч Н.Мөнхжаргал гэсэн дарааллаар тойргийн журмаар даргалуулахаар тус тус тогтоов.

2.4. Тус шүүхэд шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүйн улмаас хуульд заасан үндэслэлээр адил шатны өөр шүүхийн нэг шүүгч шүүх бүрэлдэхүүнд томилогдон оролцох тохиолдолд тус шүүхийн шүүгч шүүх хуралдааныг даргална.

2.5. Тус шүүхэд шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүйн улмаас адил шатны өөр шүүхээс хоёр шүүгч шүүх бүрэлдэхүүнд оролцох тохиолдолд хуралдаан даргалагчийг томилогдсон адил шатны өөр шүүхийн хоёр шүүгчээс сугалаагаар сонгоно.

3. Хэрэг хуваарилагдсан буюу илтгэх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй хуульд заасан үндэслэл үүссэн, эсхүл шүүгч хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар 30 хоногоос дээш хугацаагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй нөхцөл /өвчлөх, чөлөөтэй гэх зэрэг/ үүсвэл тухайн шүүгчид хуваарилагдсан хэргийг нэгдсэн системээс санамсаргүй тохиолдлын аргаар дахин хуваарилна. Давж заалдах журмаар хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнээр шийдвэрлэдэг онцлогоос хамаарч шүүгч ээлжийн амралттай тохиолдолд хэргийг дахин хуваарилахгүй.

4. Хяналтын шатны шүүхээс дахин хэлэлцүүлэхээр буцаасан, адил шатны өөр шүүхээс шилжүүлсэн, тус шүүхэд харьяалал тогтоон ирүүлсэн хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулах тухай хүсэлт, гомдлыг энэ тогтоолын 1.1, 1.2-т заасан журмаар шүүгчид хуваарилна.

5. Тус шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхийн шүүх бүрэлдэхүүнд томилогдон оролцох тохиолдолд эрүүгийн болон иргэний хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд: 1. шүүгч Б.Мөнхзаяа, 2. Ерөнхий шүүгч Л.Алтан, 3. шүүгч Н.Мөнхжаргал гэсэн дараалал /сугалаа сугалж дарааллыг тогтоов/-ын дагуу тойргийн журмаар шүүгчийг санал болгоно. Тухайн сонгогдсон шүүгч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх бүрэлдэхүүнд оролцох боломжгүй бол дараагийн шүүгчийг санал болгоно.

6. Иргэний хэргийн шүүхээр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад гарсан Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5, 15.7 дугаар зүйлд заасан зөрчилд шийтгэл оногдуулсан шүүгчийн шийтгэвэрт оролцогчийн гаргасан гомдлоор хэргийг хүлээн авч, нэгдсэн системээс санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилах боломжгүй /одоогоор Иргэн-2014 нэгдсэн системд бүртгэх цэс байхгүй/ тул тухайн зөрчлийн хэргийг: 1. Ерөнхий шүүгч Л.Алтан 2. шүүгч Н.Мөнхжаргал, 3. шүүгч Б.Мөнхзаяа гэсэн дарааллаар тойргийн журмаар хуваарилахаар сугалаа сугалж тогтоов.

7. Хорих ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллаж, хяналт тогтоох тухай прокурорын дүгнэлтийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид гаргасан

гомдол, эсэргүүцлээр хэргийг хүлээн авч, нэгдсэн системээс санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилах боломжгүй /одоогоор эрүүгийн нэгдсэн системд бүртгэх цэс байхгүй/ тул тухайн хэргийг: 1. Ерөнхий шүүгч Л.Алтан 2. шүүгч Н.Мөнхжаргал, 3. шүүгч Б.Мөнхзаяа гэсэн дарааллаар тойргийн журмаар хуваарилахаар сугалаа сугалж тогтоов.

8. Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилах болон шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоохтой холбоотой энэ журмаар зохицуулагдаагүй асуудлууд гарвал тухай бүр нь ээлжит бус шүүгчдийн зөвлөгөөнийг хуралдуулж шийдвэрлэнэ.

Монгол Улсын Шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсгийн 19.2.2, 19.2.5 дахь заалт, 19.3, 19.5, 19.8 дахь хэсэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2, 5 дахь хэсгүүд, 3.3 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгүүд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 78.1, 78.2, 78.4, 78.6 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 166 дугаар зүйлийн 166.3 дахь заалт, Нийт шүүгчдийн чуулганы 2021 оны 10 дугаар сарын 11-ний өдийн 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан, Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам, Нийт шүүгчдийн чуулганы 2023 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 04 дүгээр тогтоолыг тус тус удирдлага болгон,

ТОГТООХ нь:

1. Тус шүүхэд ирсэн эрүү, иргэн, зөрчлийн хэрэг, гомдол, хүсэлтийг нэгдсэн системээс урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилахдаа ердийн журмаар хэрэг хуваарилах аргыг хэрэглэж, нэгдсэн системд шүүгчдийн нэрсийг дараах дарааллаар тус тус байршуулахаар тогтоосугай. Үүнд:

1.1. Эрүү, зөрчлийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд:

1.1.1. Шүүгч Б.Мөнхзаяа,

1.1.2. Шүүгч Н.Мөнхжаргал,

1.2.3. Ерөнхий шүүгч Л.Алтан гэсэн дарааллаар,

1.2. Иргэн-2014 нэгдсэн системд:

1.2.1. Ерөнхий шүүгч Л.Алтан,

1.2.2. Шүүгч Б.Мөнхзаяа,

1.2.3. Шүүгч Н.Мөнхжаргал гэсэн дарааллаар.

2. Шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг дараах журмаар тогтоосугай. Үүнд:

2.1. Ерөнхий шүүгч Л.Алтангийн илтгэх эрүү, иргэн зөрчлийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаан даргалагчаар: 1. шүүгч Б.Мөнхзаяа, 2. шүүгч Н.Мөнхжаргал гэсэн дарааллаар тойргийн журмаар.

2.2. Шүүгч Н.Мөнхжаргалын илтгэх эрүү, иргэн, зөрчлийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаан даргалагчаар: 1. шүүгч Б.Мөнхзаяа, 2. Ерөнхий шүүгч Л.Алтан гэсэн дарааллаар тойргийн журмаар,

2.3. Шүүгч Н.Мөнхзаяагийн илтгэх эрүү, иргэн, зөрчлийн хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаан даргалагчаар: 1. Ерөнхий шүүгч Л.Алтан, 2. шүүгч Н.Мөнхжаргал гэсэн дарааллаар тойргийн журмаар,

2.4. Тус шүүхэд шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүйн улмаас хуульд заасан үндэслэлээр адил шатны өөр шүүхийн нэг шүүгч шүүх бүрэлдэхүүнд томилогдон оролцох тохиолдолд тус шүүхийн хэрэг илтгээгүй шүүгч шүүх хуралдааныг даргалахаар,

2.5. Тус шүүхэд шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүйн улмаас адил шатны өөр шүүхээс хоёр шүүгч шүүх бүрэлдэхүүнд оролцох тохиолдолд хуралдаан даргалагчийг, адил шатны өөр шүүхээс томилогдсон хоёр шүүгчээс сугалаагаар сонгохоор тус тус тогтоосугай.

3. Хяналтын шатны шүүхээс дахин хэлэлцүүлэхээр буцаасан, адил шатны өөр шүүхээс шилжүүлсэн, тус шүүхэд харьяалал тогтоон ирүүлсэн хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулах тухай хүсэлт, гомдлыг энэ тогтоолын 1.1, 1.2 дахь заалтад заасан журмаар шүүгчид хуваарилсугай.

4. Хэрэг хуваарилагдсан буюу илтгэх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй хуульд заасан үндэслэл үүссэн, эсхүл шүүгч хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар 30 хоногоос дээш хугацаагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй нөхцөл /өвчлөх, чөлөөтэй гэх зэрэг/ үүсвэл тухайн шүүгчид хуваарилагдсан хэргийг нэгдсэн системээс санамсаргүй тохиолдлын аргаар дахин хуваарилахаар, давж заалдах журмаар хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнээр шийдвэрлэдэг онцлогоос хамаарч шүүгч ээлжийн амралттай тохиолдолд хэргийг дахин хуваарилахгүй байхаар тус тус тогтоосугай.

5. Тус шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхийн шүүх бүрэлдэхүүнд томилолтоор ажиллах тохиолдолд дараах дарааллаар шүүгчдийн нэрсийг санал болгосугай.

5.1. шүүгч Б.Мөнхзаяа, Ерөнхий шүүгч Л.Алтан, шүүгч Н.Мөнхжаргал гэсэн дарааллын дагуу тойргийн журмаар.

5.2. Тухайн сонгогдсон шүүгч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх бүрэлдэхүүнд оролцох боломжгүй нөхцөл үүссэн бол дараагийн шүүгчийг санал болгох.

6. Иргэний хэргийн шүүхээр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад гарсан Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5, 15.7 дугаар зүйлд заасан зөрчилд шийтгэл оногдуулсан иргэний хэргийн шүүгчийн шийтгэвэрт оролцогчийн гаргасан гомдолтой хэргийг: Ерөнхий шүүгч Л.Алтан, шүүгч Н.Мөнхжаргал, шүүгч Б.Мөнхзаяа гэсэн дарааллаар тойргийн журмаар хуваарилсугай.

7. Хорих ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллаж, хяналт тогтоох тухай прокурорын дүгнэлтийг хянан шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид гаргасан гомдол, эсэргүүцэлтэй хэргийг: Ерөнхий шүүгч Л.Алтан, шүүгч Н.Мөнхжаргал, шүүгч Б.Мөнхзаяа гэсэн дарааллаар тойргийн журмаар хуваарилсугай.

8. Хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилах болон шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоохтой холбоотой энэ журмаар зохицуулагдаагүй асуудал гарвал тухай бүр нь ээлжит бус шүүгчдийн зөвлөгөөнийг хуралдуулж шийдвэрлэхээр тогтоосугай.

9. Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, Иргэн-2014 нэгдсэн систем цахим программуудад зөвлөгөөнөөс тогтоосон дарааллын дагуу шүүгчдийн нэрсийг байршуулахдаа энэ тогтоолд зааснаар тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилагдах сонголтыг нэгдсэн системд тохируулан зохих тохиргоог хийх, зөвлөгөөний тогтоолын хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг шүүхийн Тамгын газрын дарга Л.Баттулга, мэдээлэл технологийн мэргэжилтэн Д.Цэвээндорж нарт үүрэг болгосугай.

10. “Эрүүгийн болон зөрчлийн хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шүүгчид хүлээлгэн өгөх журам”-ыг 01 дүгээр хавсралтаар, “ Иргэний хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шүүгчид хүлээлгэн өгөх журам”-ыг 02 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

11. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т зааснаар энэ тогтоолын биелэлтийг зохион байгуулж ажиллахыг Ерөнхий шүүгч Л.Алтанд хариуцуулж, тогтоолын нэг хувийг шүүхийн Тамгын газарт хүргүүлэхийг шүүгчийн туслах Ш.Анхцэцэгт даалгасугай.


12. Энэхүү тогтоол батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх тул тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Эрүү, иргэн, зөрчлийн хэрэг, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох, шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох журам”-ыг шинэчлэн батлах тухай 01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Л.АЛТАН

ШҮҮГЧ

Б.МӨНХЗАЯА



Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 12-р сарын 15-ны өдрийн 31 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ИРГЭНИЙ ХЭРЭГ, ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ШҮҮГЧИД ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ЖУРАМ

Нэг. Хэрэг, хүсэлт, гомдол хүлээж авах

1.1. Давж заалдах шатны шүүхэд иргэний хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах, шүүгчид Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Иргэн-2014 /цаашид “нэгдсэн систем” гэх/ нэгдсэн системээр хуваарилахдаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 205 дугаар тогтоолоор батлагдсан Иргэний хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлал, хэрэг хуваарилах шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, энэхүү журмыг баримтална.

1.2. Анхан шатны шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 163 дугаар зүйлийн 163.3-т заасны дагуу давж заалдах шатны шүүхэд ирүүлсэн хэрэг, гомдол, хүсэлтийг шүүгчийн туслах нэгдсэн системээс энэхүү журамд зааснаар шүүгчид хуваарилан, бүртгэлд бүртгэж давж заалдах шатны шүүхэд хүлээн авсан, ирсэн огноо, цаг минутыг тэмдэглэж, хуваарилагдсан шүүгчид /илтгэгч/ нэн даруй хүлээлгэн өгнө.

1.3. Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу шүүгчийн туслах хэрэг, хүсэлт, гомдлыг хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг оролцогч этгээдийн хүсэлтээр хэвлэн өгч, баримтыг хэрэгт хавсаргана.

1.4. Шүүгчийн туслах Шүүхийн ерөнхий 2024 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн 205 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан заавраар хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хүлээлгэж өгсөн тухай зохих бүртгэл үйлдэж, бүртгэлд шүүгчээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.

Хоёр. Хэрэг, хүсэлт, гомдол хуваарилах

2.1. Давж заалдах гомдолтой хэрэг, адил шатны шүүхээс шилжиж ирсэн хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулахаар ирүүлсэн хүсэлтийг энэхүү журамд зааснаар шүүгчид хуваарилахдаа урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотроо санамсаргүй тохиолдлоор хуваарилах тохиргоог үндэслэнэ.

2.2. Хэргийг шүүх хуралдаанд илтгэж танилцуулах шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84, 91 дүгээр зүйлд заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож болохгүй үндэслэл тогтоогдвол тухайн иргэний хэрэг, хүсэлтийг тус шүүхийн өөр шүүгчид энэ тогтоолд зааснаар тойргийн журмаар хуваарилна.

2.3. Монгол улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т зааснаар иргэний хэрэг, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас дахин хянуулахаар ирүүлсэн хүсэлтийг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн болон шүүх хуралдаан даргалагчийг томилсон шийдвэрийг тус шүүхийн ерөнхий шүүгчийн захирамжаар албажуулна.

2.4. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчоос гаргасан гомдол, хүсэлтийг шүүгчийн туслах хүлээн авч, огноо, цаг минутыг тэмдэглэж, тухайн хэрэг хуваарилагдсан шүүгчид /илтгэгч/ нэн даруй хүлээлгэн өгч, энэ талаар бүртгэл үйлдэнэ.

Гурав. Бусад

3.1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.6 дахь хэсэгт зааснаар иргэний хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх өөр аймаг, нийслэлийн шүүхийн бүрэлдэхүүнд Ерөнхий шүүгч Л.Алтан, шүүгч Н.Мөнхжаргал, шүүгч Б.Мөнхзаяа нарыг тухайн шүүхийн зөвлөгөөний тогтоолд заасан журмын дагуу томилон оролцуулна.

3.2. Тус шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхийн бүрэлдэхүүнд томилолтоор ажиллах тохиолдолд тухайн адил шатны шүүхээс ирүүлсэн албан бичигт дурдсан иргэний хэргүүдийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүний шүүгчээр томилуулахаар сонгогдсон шүүгчийн нэрийг албан бичгээр хүргүүлнэ.

3.3. Өөр шүүхийн шүүх бүрэлдэхүүнд оролцохоор сонгогдсон шүүгч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас томилолтоор ажиллах боломжгүй болсон тохиолдолд дараагийн шүүгчийг шүүх бүрэлдэхүүнд томилуулахаар санал болгоно.

3.4. Адил шатны шүүхээс тус шүүхийн бүрэлдэхүүнд шүүгч томилон оролцуулах тухай саналыг тухайн шүүхэд албан бичгээр хүргүүлэн баримтжуулж хэрэгт хавсаргана.

3.5. Шүүгч ээлжийн амралттай байх үед түүнд хуваарилагдсан хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэрэгт заасан хугацаанд багтааж шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд шүүгчид ээлжийн амралтыг нь тухайн шүүгчийн зөвшөөрлөөр хэсэгчлэн эдлүүлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулж болно.

3.6. Шүүгчид хэрэг, өргөдөл гомдол, хүсэлт хуваарилагдахгүй байх нөхцөл бий болсон бол хугацааг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.7. Тус шүүхийн шүүгчдийн тоо нэмэгдэх, хасагдах хэрэг, өргөдөл, гомдол, хүсэлт хуваарилагдах явцад энэ журмаар зохицуулагдаагүй асуудлууд гаргавал тухай бүрд нь шүүгчдийн ээлжит бус зөвлөгөөнийг хуралдуулж шийдвэрлэнэ.

3.8. Давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг шүүгчийн туслах эмхэтгэж шүүгчээр /илтгэгч/ хянуулж, зохих баримтыг үйлдэн, хэрэгт хавсаргаж, хэргийг ирүүлсэн анхан шатны шүүхэд тус шүүхийн Ерөнхий шүүгчийн албан бичгээр хүргүүлнэ.